



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

Орон сууц хувьчлах товчоо  
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Орон сууц хувьчлах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам”-ын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төв аймгийн орон сууц хувьчлах товчоог хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

2.Орон сууц хувьчлах тухай хууль тогтоомж, “Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам”-ыг мөрдөж ажиллахыг товчоонд үүрэг болгосугай.

3.Товчооны үйл ажиллагааны зардлыг зохих журмын дагуу тооцож, төсөвт тусган санхүүжүүлэхийг Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргалд зөвлөсүгэй.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001701



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2018 оны 05 дугаар сарын 23-ны  
өдрийн 19/ дугаар тогтоолын хавсралт



ТӨВ АЙМГИЙН ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ  
ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Товчооны дарга

Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө  
оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн  
хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,  
төрийн сангийн хэлтсийн дарга

Орон нутгийн өмчийн газрын дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын дарга

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

“Төв-Чандмань” орон нутгийн өмчит аж ахуйн  
тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал

----- о О о -----